

Үйлдвэрлэлийн зориулалтаар загас олборлох заламгайн тор. Ерөнхий шаардлага	MNS 5974:2009
Gill nets for commercial fishing. General requirements	

Стандартчилал, Хэмжил Зүйн Үндэсний Зөвлөлийн 2009 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 16 дугаар тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь улсын бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн хүчинтэй.

Энэ стандартын бүх шаардлагыг заавал мөрдөнө.

1. Зорилго

Агнуурын нөөц бүхий нууруудын загасны популяцийн тэнцвэрт харьцааг алдагдуулахгүйгээр, агнуурын загасны насны бүлгэмдэл, тэдгээрийн харьцаанд тохируулан загас олборлох заламгайн торны нүдний хэмжээг тодорхойлох, зохицуулахад оршино.

2. Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь агнуурын эрх бүхий аж ахуйн байгууллага, төрийн захиргааны төв байгууллагаас эрх авсан орон нутгийн мэргэжлийн байгууллагын агнуурт хэрэглэх заламгайн торны нүдний хэмжээг тодорхойлох, хяналт шалгалт, үнэлгээ хийхэд хамаарна.

3. Норматив ишлэл

Энэ стандартад олон улсын болон үндэсний дараах стандартуудыг иш татсан бөгөөд өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны эх материалаас иш татаж хэрэглэнэ.

- ISO 1107:2003, Тор тавих үндсэн зарчим
- ISO 16662-1:2009, Торны нүдний хэмжээг хянах аргачлал

4. Нэр томьёо, тодорхойлолт

4.1

Заламгайн тор

Дээд талдаа хөвөгчтэй, доод талдаа хүндрүүлэгчтэй хэц маягаар татсан суурин тор (1-р зураг)

4.2

Заламгайн торны нүдний хэмжээ

Заламгайн тор нь загасыг сонгож барих учир нүдний хэмжээ нь барих загасны биеийн тойргийн уртаар зохицуулагдана (2-р зураг)

4.3

Агнуурын загасны ерөнхий урт

Хошууны үзүүрээс сүүлний сэлүүрийн төгсгөл хүртэл хэмжсэн урт

4.4

Агнуурын урт

Хошууны үзүүрээс нурууны сүүлчийн нугалам хүртэл буюу хайрсны төгсгөл хүртэлх урт

4.5

Агнуурын загасны биеийн тойргийн урт

Биеийн хамгийн өндөр хэсгээр буюу нурууны сэлүүрийн урд хэсгээр биеийг бүхэлд нь тойрон хэмжсэн урт

5. Ангилал

5.1

Дан хэцтэй заламгайн тор

Ганц эрчлээстэй эсвэл олон эрчлээстэй нийлэг буюу мяндсан утсаар хийсэн хэц маягаар татсан тор

5.2

Давхар хэцтэй заламгайн тор

Том нүдтэй хоёр торны дунд жижиг нүдтэй тор байрлуулсан. Загас торны аль нэг талаар нэвтрэн орж том болон жижиг нүдтэй торонд орооцолдоно.

6. Ерөнхий шаардлага

6.1. Үйлдвэрлэлийн зориулалтаар загас олборлох

6.1.1. Агнуур явуулах эрх

Тухайн жилд зөвшөөрөл олгосон агнуурын нөөц бүхий нуураас агнуурын эрх авсан аж ахуйн байгууллага, төрийн захиргааны төв байгууллагаас

эрх авсан орон нутгийн мэргэжлийн байгууллага агнуур явуулах зөвшөөрлийн хугацаанд загас олборлоно.

6.1.2. Заламгайн торны нүдний хэмжээг сонгох

Агнуурын нөөц бүхий нууруудын загасны биологийн онцлогоос хамааран заламгайн торны нүдний хэмжээ, өргөнийг бүс нутаг бүрээр нь ангилан 1-р хүснэгтэд тодорхойлов.

Хүснэгт 1

Агнуурын нөөц бүхий нууруудаас загас олборлох заламгайн торны нүдний хэмжээ, түүнд тохирох агнуурын загасны биеийн урт

Аймгийн нэр	Нуурын нэр	Заламгайн торны нүдний хэмжээ	Заламгайн торны өргөн	Агнуурын загасны нэр	Түүнд тохирох агнуурын загасны биеийн урт
Хөвсгөл	Цагааны нуурын Дунд хэсэг	40×40, 50×50 мм дээш	2.0-4.0 м	Цагаан загас	380 мм дээш
	Тарган нуур	40×40, 50×50 мм дээш	1.5-2.0 м	Цагаан загас	380 мм дээш
				Бух зарам	330 мм дээш
Хармай нуур	40×40, 50×50 мм дээш	4.0-6.0 м	Цагаан загас	380 мм дээш	
Архангай	Өгий нуур	50×50 мм дээш	2.0-4.0 м	Алгана	250-280 мм дээш
				Улаан нүдэн	200-230 мм дээш
				Цурхай	300-400 мм дээш
				Булуу цагаан	300-380 мм дээш
Баян-Өлгий	Толбо нуур	50×50 мм дээш	4.0-6.0 м	Алтайн сугас	450 мм дээш
Увс	Ачит нуур	50×50 мм дээш	1.5-2.0 м	Алтайн сугас	495 мм дээш
				Монгол хадран	450 мм дээш
Завхан	Баян нуур	50×50 мм дээш	4.0-6.0 м	Алтайн сугас	440 мм дээш
	Улаагчны Хар нуур		4.0-6.0 м	Бух зарам Омуль	350-420 мм 390-450 мм дээш
Дорнод	Буйр нуур	50×50 мм дээш	2.0-4.0 м	Цурхай	450 мм дээш
				Булуу цагаан	400 мм дээш
				Хэлтэг	250 мм дээш
				Улаан далбаат	350 мм дээш
	Хөх нуур	40×40, 50×50 мм дээш	2.0-4.0 м	Хэлтэг	250 мм дээш

6.1.3. Заламгайн тор тавих

Зуны улиралд заламгайн тор тавих

Заламгайн торны өргөний хэмжээнээс хамааран нуурын тодорхой гүнд торны нэг талын живүүрийн хэсэгт хүндрүүлэгч бэхлэн завийг удаан сэлүүрдэн торны хөвүүр усны мандалд, живүүр усны ёроолд байхаар тохируулан завин дээрээс торыг хөврүүлэн тавина. Торны байрлалыг түүний 2 захад байрлуулсан хөвөгчийн тусламжтайгаар тогтооно.

Өвлийн улиралд заламгайн тор тавих

Өвлийн улиралд мөсний зузаанаас хамааран торны урт, өргөний хэмжээг тооцоолсны үндсэн дээр тодорхой зайнд мөсийг цоолон, цооног бүр дээр заламгайн торны хөвүүр харагдаж байхаар тооцон торыг тавина. Торны хоёр захын үзүүрийг доош унахгүйгээр мөсөнд наалдуулан сайн бэхэлж өгөх хэрэгтэй.

6.1.4. Заламгайн тор татаж авах

Шаардлагатай хугацаа өнгөрсний дараа заламгайн торыг буцаан авахдаа нэг үзүүрээс нь эхлэн урсгалын болон салхины чиглэлийн дагуу эсвэл цооногийн нэг захын хөвүүрийн үзүүрийг султган нөгөө захын үзүүрээс аажуухан татаж торыг гаргана.

6.1.5. Заламгайн торноос загас салгах

Торыг уснаас гаргамагц загасыг хурдан салгаж авна. Загасны заламгайн хавхагыг гэмтээхгүйн тулд жижиг дэгээгээр торны нүхнээс хөндийрүүлэн эсвэл сүүлний уг руу шувтрах хэлбэрээр салгана.

6.1.6. Заламгайн торыг цэвэрлэх, хураах

Загасыг бүрэн салгасны дараа торонд наалдсан элдэв ургамлын үлдэгдэл, хогийг цэвэрлэн жигд татан дэлгэнэ. Дээд, доод хэцнээс 2 хүн барин нэгэн жигд алдлан хураана.

6



1-р зураг. Заламгайн тор. Заламгайн торны нүдний хэмжээ



Зураг 2. Агнуурын загасны биеийн урт болон тойргийн уртын хэмжээ:
А – Агнуурын урт (хошууны үзүүрээс нурууны сүүлчийн нугалам хүртэл буюу хайрсны төгсгөл хүртэлх урт); Е – Ерөнхий урт (хошууны үзүүрээс сүүлний сэлүүрийн төгсгөл хүртэлх урт); Т – Биеийн тойргийн урт (биеийн хамгийн өндөр хэсгээр буюу нурууны сэлүүрийн урд хэсгээр биеийг бүхэлд нь тойрон хэмжсэн урт)

Хавсралт (мэдээллийн)

Ашигласан материалын жагсаалт

- Амьтан, ургамлын холбогдолтой хууль тогтоомжийн эмхтгэл. 2006. Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг, Улсын мэргэжлийн хяналтын газар
- Баасанжав Г. 2004. Дархадын хотгорын Доод Цагаан нуурын загасны экологи, нөөцийн судалгаа. Эрдэм шинжилгээний ажлын тайлан
- Буйр нуурын загасны нөөц, жилд олборлох хэмжээ. 1998. "Эрчим хүч-Байгаль орчин" ХХК. Тайлан
- Дулмаа А. 1980. Баян-Өлгий аймгийн зарим нуурыг агнуурт ашиглах боломжийн тухай биологийн үндэслэл. Зөвлөмж
- Дулмаа А. 2007. Омуть (*Coregonus autumnalis migratorius* Georgi, 1775) загасыг баруун Монголын говийн нууруудаар үржүүлсэн биологийн судалгааны үндэслэл. Шинжлэх Ухааны Мэдээ. №2: 36-47
- Соколов В.Н. и др. 1985. Экология и хозяйственное значение рыб МНР
- Цэрэнсодном Ж. 1966. Бойр нуурт явуулсан судалгааны ажлын тайлан. Газарзүйн хүрээлэнгийн фонд.
- Эрдэнэбат М. 2000. Хөх нуурын загасны нөөц, жилд олборлох хэмжээ. "Эрчим хүч-Байгаль орчин" ХХК. Тайлан
- Эрдэнэбат М. 2002. Хөх нуурын загасны нөөцийг хамгаалах, ашиглах үндэслэл. МОНРИЕЛ ХХК. Тайлан
- Эрдэнэбат М., Отгонтуул П. 2006. Хөх нуурын загасны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах үндэслэл. Геоэкологийн хүрээлэнгийн тайлан
- ISO 2003, International Standard Organization, (online), <http://www.iso/en/stdsdevelopment/tc/tclsit/TechnicalCommitteeStandardslistPage. TechnicalCommitteeStandardsList?COMMID=36018&INCLUD=ESC=YES>, (2003)
- Mika Kurkilahti., Martti Rask. 1996. A comparative study of the usefulness and catch ability of multi mesh gill nets and gill net series in sampling of perch (*Perca fluviatilis* L.) and roach (*Rutilus rutilus* L.)// Fisheries Research 27: 243-260.